



БАГШ БОЛОВСРОЛЫН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН (PLO)-Г ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА (БАГШ, БАГА БОЛОВСРОЛ ХӨТӨЛБӨРИЙН ЖИШЭЭН ДЭЭР)

Г.Бямбацэрэн^а, Ц.Тамир^б

^аМУБИС-Багшийн сургууль, дэд профессор;

^бМУБИС-Багшийн сургууль, доктор

Холбоо барих зохиогч: byambatseren.edu.mn, ts.tamir@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2025.08.25

Хянагдсан: 2025.09.25

Зөвшөөрсөн: 2025.11.05

Хураангуй

Боловсролын аливаа асуудалд системийн сэтгэлгээгээр хандах, юуны түрүүнд үр дүнд суурилсан хөтөлбөр хэрэгжүүлэх асуудал чухал гэдгийг судлаачид олонтоо дурдсан ч улс орон болгон хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тодорхойлохдоо юуг юуны учир шинээр оруулах, юуг юуны учир үлдээх, юуг дахин сайжруулах вэ гэдгийг илүүтэй чухалчилсан байдаг.

Хөрс нь тохирохгүй газар ургамал тарихтай адил олон улсын хөтөлбөрт барьж байгаа онол арга зүй, үзэл баримтлалыг харгалзан үзэх ч харьцуулсан судалгаа байхгүйгээр яаж шинээр оруулах, байгаагаа яаж хөгжүүлэх, юуг халж чаддаг байх нь хөтөлбөрийг дахин дизайнчлахад хамгийн чухал шийдэл гэж үзлээ. Багш боловсролын хөтөлбөрийн суралцахуйн үр дүн smart биш (хэт олон, хэмжигдэхүйц бус...) учраас дахин томъёолох. Олон улсын багш боловсролын хөтөлбөрийн суралцахуйн үр дүн 6-12 чадамжийн хүрээгээр тодорхойлсныг жишиг болгож, 12 үр дүнд суурилсан Багш, бага боловсрол хөтөлбөрийн үр дүнг тодорхойлсон. Үр дүнд суурилсан хөтөлбөр боловсруулах жишиг ШУТИС-ийн профессорын баг боловсруулсан ч багш боловсрол, инженерийн боловсролоос өөр учир бид олон улсын хөтөлбөр боловсруулах аргачлалыг харьцуулан харахыг оролдсон.

Түлхүүр үг

Багш боловсрол, хөтөлбөрийн үр дүн(PLO), амьдралын чанар, чадамж, системийн сэтгэлгээ, мэдлэгийг бүтээх

Удиртгал

Багш боловсролын хөтөлбөрийн үр дүнг оновчтой томьёолох, багш бэлтгэдэг хөтөлбөрийн суралцахуйг дахин томьёолоход суралцагчийн хөгжлийн онцлог, нийгмийн хөгжлийн онцлогийг харгалзахын зэрэгцээ уламжлалт боловсролын үнэ цэн, дэлхийн иргэн монгол хүнийг бэлтгэхэд төвлөрсөн байх. Үүний тулд дэлхийн иргэнийг бэлтгэх боловсролын зорилго, суралцахуйн үр дүн юунд, юуны учир, хэрхэн чиглэж байгааг харьцуулан судлах, багш бэлтгэх хөтөлбөрийн үзэл баримтлал, суралцахуйн үр дүн дэлхийн иргэнийг бүтээх замналаа нийцтэй томьёолж тодорхойлж, хэрэгжүүлж чадаж байгаа эсэхийг харьцуулан судлахыг хичээсэн. Судалгаанд суурилан “**Багш, бага боловсрол хөтөлбөр**”-ийн суралцахуйн үр дүнг дахин шинэчилж боловсруулах, суралцахуйн үр дүнд чиглэсэн сургалтын төлөвлөгөө, судлагдахуун бүрийн зорилго, зорилт, арга зүй, үнэлгээ, суралцахуйн загварыг хүртэл өөрчлөх хэрэгцээ үүсэж байна. 2023 оноос хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгээ шинэчлэн сайжруулж оновчтой, цомхон, smart байдлаар тодорхойлохыг чухалчилж, зарим нэг хичээлийг шинээр сургалтын төлөвлөгөөнд оруулж судалж байна. (Кодчилал, Дижитал бичиг үсэг, EQ хөгжүүлэх арга зүй, Эцэг эхтэй ажиллах арга зүй, Боловсролын зөвшилцөл, Унших стратеги эзэмших арга зүй, Номын сан судлал, Сэтгэл хөдлөл, нийгэмшихүйд суралцахуйн боловсрол, Ялгаатайд ялгаатай суралцахуйн онол арга зүй, Ангийн менежмент, STREAM..)

Үндсэн хэсэг: Багш, бага боловсрол хөтөлбөрийн олон улсын харьцуулсан судалгаа

Багш, бага боловсрол хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тодорхойлохын тулд хөтөлбөрийн зорилгоо дахин тодорхойлох, тодорхойлохдоо юуг цоо шинээр оруулах, юуг үлдээх, юуг дахин сайжруулж дизайнчлах алхмыг хийж дараах 4 зорилгыг дэвшүүлсэн.

1. Хүүхдийн хэрэгцээ болон ялгаатай байдлыг нь ойлгодог, сурах хүсэл эрмэлзлийг нь төрүүлдэг, хүмүүнлэг, хүнлэг энэрэнгүй, үнэт зүйлээ эрхэмлэдэг багш байх
2. Судлагдахууны мэдлэгтэй, багшлахуй суралцахуйн онол, арга зүйг эзэмшсэн, хүүхдийн хөгжлийг оношилдог, оюунлаг багш байх
3. Тогтвортой хөгжил, сайн сайхан, монгол хүний үнэт зүйлийг эрхэмлэдэг, харилцаа, технологийн чадвартай, санаачлагч, хөгжүүлэгч, бүтээлч багш байх
4. Судлаач, мэдлэгээ бүтээлчээр хэрэглэдэг, асуудлыг хамтран шийдвэрлэдэг, боловсролын хөгжилд хувь нэмрээ оруулдаг, насан туршдаа тасралтгүй суралцагч багш байх

Дээрх зорилгыг томьёолж гаргахдаа Б.Жадамба багшийн монгол багшийн дүр төрх, (багш боловсролын хөтөлбөрийн үзэл баримтлал, 2023), хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ өөрчлөгдөн хөгжигч багшийг бэлтгэх хөтөлбөрийг когнитив, конструктив онолд суурилан, насанд хүрэгчдийн суралцахуй (androgogy)-н аргазүйг тусган боловсруулж, “эрдэм чанар”-ыг эзэмших суралцахуй, багшлахуй бүхий “transformative learning” (Jack Mezirow, 2009) -д тулгуурлах зарчмаар зохион байгуулж хэрэгжүүлэхээр боловсруулсан. Түүнчлэн 37 орны суралцахуйн үр дүн болон баримталсан онол, зарчмыг харьцуулан авч үзсэнээс түүвэр байдлаар дараах хөтөлбөрүүдийг харьцуулж үзлээ.

Хүснэгт 1. Суралцахуйн үр дүнгийн харьцуулалт

улс	Монгол	Финлянд	Сингапур	БНСУ	АНУ	Канад	Австрали
Суралцахуйн үр дүнгийн онолын үндэс, зарчим	Үзэл баримтлал, Үндэсний сургалтын стандарт, хөтөлбөр, уламжлалт сургалтын загвар, Боловсролын хууль	Судалгаанд суурилсан боловсрол	OBE(outcome-based education), teacher education Model for the 21st century	Үндэсний уламжлалт төвтэй, сургалтын стандарт, шалгалт чухал	In TASC model core teaching standarts, competency based education	Тэгш хамрах, суралцагчийн идэвх оролцоог чухалчлах	Багш мэргэжлийн стандартын хүрээ(AITSL)
онцлог	Стандартын дагуу сургалт төлөвлөх, цуваа хөтөлбөр давамгайлсан, мэргэжлийн суурь мэдлэгтэй байхыг чухалчилсан, уламжлал суурьтай	Багш судлаач байх, хамтын сургалтад суурилсан	21-р зууны багшийн загварыг үр дүнд суурилсан боловсрол, манлайлал, ёс зүй, бүтээлч чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн	Төвлөрсөн хөтөлбөр, мэдлэгийн нарийвчлал, үр дүнг шалгалтаар хэмжих чиг хандлагатай,	суралцагч төвтэй хүртээмжтэй, багшийн мэргэжлийн чадамжуудыг хослуулах, орон нутгийн онцлогт нийцүүлэх	Суралцагч төвтэй хүртээмжтэй боловсрол бодлого хэрэгжүүлж хүртээмж, олон талт байдал, идэвх сонирхлыг дэмжих	Багшийн ур чадвар, ёс зүй, туршлага, инновац

Хүснэгт 1-ийн харьцуулалтад:

- Үр дүнд суурилсан боловсролын онол, хөтөлбөрийн зорилго (Spady,W. (1994). Outcome-Based education; Critical issues and answers *Biggs, J., Tang,C (2011). Teaching for quality learning at university * МУБИС-ийн Багш боловсролын үзэл баримтлал (2023))
- 21-р зууны чадварууд ((2012, 2022).UNESCO: бүтээлч сэтгэлгээ, харилцаа, хамтын ажиллагаа, дижиталь чадвар, асуудал шийдэх,+дасан зохицох)
- Олон улсын стандартууд болон СҮД (InTASC(USA), AITSL(Abs))
- Нийгмийн хэрэгцээ, хөдөлмөрийн зах зээл(ажил олгогчдын хэрэгцээ, төгсөгчдийн сэтгэл ханамж)
- Хичээлүүдийн болон хөтөлбөрийн үр дүнгийн уялдаа (PLO, CLO-гийн матриц) зэргийг харьцуулалтын чиглэл, онол, бодлогын баримт бичиг болгон авсан байна.

Түүнчлэн хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тодорхойлохдоо дараах чиг хандлага, онолыг суурь болгон авч үзлээ.

Прагматизм - үйлдэл-зөвлөгч (боловсрол бол өөрийн амьдралаа хүссэнээрээ зохиоход туслах хэрэгсэл, хүн бодит байдлыг өөрийн хүсэл, сонирхлын дагуу бүрдүүлдэг.)

Экспериментализм – туршлага- туслагч (прагматизмын нэг төрөл, боловсролын гол хүчин зүйл туршлага, боловсролын гол зорилго суралцагч өөрийн гэсэн ертөнцийг үзэх үзэлтэй, итгэл үнэмшил, боловсролыг олгохдоо суралцагчийн хувийн хэрэгцээ, сонирхолд үндэслэнэ.)

Багшийн үүрэг сурах соёлыг бий болгох, дасгалжуулагч байх, харилцан яриа, маргаан, мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлж, нийгмийн харилцааг дэмжиж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлдэг байх ёстой (Ариунболд.Ж, 2022.,СХБОАЗ)

Боловсролын салбарт баримталж буй үзэл баримтлал, парадигмын нөөц шавхагдсаныг ухаарч системийн сэтгэлгээний үндсэн дээр бүх талын оролцоотой боловсролын систем, сургалтын байгууллагуудыг дахин дизайн хийх (Бадарч.Д, Системийн сэтгэлгээ)

Мэдлэгийг нээж бүтээх замаар сурах, суралцагч төвтэй хандлагатай, хамтарч сурах, онол туршлагыг хосолсон практикт чиглэсэн сургалт, бодит амьдралын асуудалд чиглэсэн, танин мэдэхэд төдийгүй ур чадвар эзэмшихэд анхаарах, танин мэдэхүйн дээд түвшний сургалт, хамтын ажиллагаатай багшийн оролцоо.

Тэгш оролцуулах, хүн бол гол үнэт зүйл, хамтрах, асуудлыг нэгтгэх, хамт олноо хөгжүүлэх, үзэл баримтлалаа өөрчлөх, хариуцлагатай, хүнийг шүтэх системийн сэтгэлгээг хөгжүүлэх

Хөтөлбөрөө боловсруулахдаа

- Хэлцэл, зөвшилцлийн үндсэн дээр боловсруулах
- Нээлттэй ч, чиглэл өгсөн, асуудалд хариу өгсөн байх
- Дэс дараа, уялдаа холбоотой мэдлэгийг чухалчлах
- Амьдралаар шалгарсан, орон нутгийн онцлогт тохирох мэдлэгт бүтээх
- Тодорхой бус байдлыг хүлээн зөвшөөрсөн мэдлэгт тулгуурлах
- Оюун ухааныг шүтэх
- Уян хатан байх
- Сонирхлын дагуу мэргэжил хоорондын мэдлэгийг чухалчлах
- Тоон ба чанарын үнэлгээ хослуулах
- Сургалтын хөтөлбөрийг баяжуулах, улам сайжруулах
- Эергээр цэгцрэх боломжтой байх
- Үйл ажиллагаа болон хөгжилд чиглэсэн байх
- Танин мэдэхүйгээс гадна бие бялдар, оюун санаа нийгэмшихүйн хөгжлийг дэмжих

Академик сургалтын онолчид аливаа хичээлийг нарийвчлан гүнзгийрүүлж судлах ёстой гэж үздэг. Хүмүүнлэгийн сургалтын хөтөлбөрийн онол суралцагч үндсэн хэрэгцээтэй туршлага олгохын чухалчилдаг бол технологийн сургалтын хөтөлбөр урьдчилан тодорхойлсон, хэмжиж болох зорилгыг чухалчилдаг. Харин системт сургалтын хөтөлбөрийн онол нь суралцагчийн гүйцэтгэл, стандартчилсан тест, ирээдүйд насанд хүрээд гүйцэтгэх үүрэгт чиглэдэг. Экзистенциалист сургалтын хөтөлбөрийн онол нь суралцагчдад оршин байх, амьдрах, сурах, суралцахад сургахад ач холбогдол өгдөг. гэх мэт онол, үзэл хандлагыг онцоллоо.


Үндсэн хэсэг: Суралцахуйн үр дүнгийн харьцуулсан судалгаа ба Багш, бага боловсрол хөтөлбөрийн суралцахуйн үр дүн

Харьцуулсан шинжилгээний хоёр дахь хэсэг хөтөлбөрийн суралцахуйн үр дүн бөгөөд үр дүнг тодорхойлохдоо ямар чадамжуудын хүрээнд тодорхойлсон, чадамжуудыг хэрхэн эрэмбэлсэн зэргээс эш үндэс болгон **Багш, бага боловсролын хөтөлбөрт** үнэт зүйл маш чухлыг гаргаж ирлээ. Тиймээс бид үнэт зүйл, хандлагыг суурь чадамж гэж тодорхойлохыг оролдсон. Харин бидний харьцуулсан хөтөлбөрүүд мэргэжлийн мэдлэг, чадвар, үнэт зүйл хандлага, инновац зэргийг нийтлэг байдлаар тодорхойлсныг хүснэгт 2. – оор харууллаа. (Bray, M., Adamson, B(2014), Comparative education research)

Сургуулийн нэр	МУБИС (MNUE)	University of Helsinki	National Institute of Education (NIE) – NTU	Seoul National University of Education (SNUe)	Stanford Graduate School of Education (Stanford GSE)	University of Alberta	University of Melbourne
Технологи / инноваци	МХТ-г сургалтад ашиглах	Сургалтад инновац нэвтрүүлэх, багш-судлаач байх	Технологийн дэвшлийг ашиглах, цахим орчинд сургалт явуулах, хөгжүүлэх	Технологийн хэрэглээ харьцангуй хязгаарлагдмал	Дижитал номын сан, ангийн систем, инновац бүтээх	Технологи ашиглах өндөр чадвар, тэрээр өөрийгөө хөгжүүлэх	Технологи, инновацын хэрэглээ өргөн байх
Хандлага / үнэт зүйл	Багшийн ёс зүйг эрхэмлэх, хамтарч ажиллах	Насан туршдаа сурацлах, амьдралын турш мэргэжлээ хөгжүүлэх, хамтын оролцоог дэмжих	Манлайлал, мэргэжлийн ёс зүйтэй байх, хамтын үнэ цэнийг эрхэмлэх	Сахилга баг, ёс зүй, үндэсний үзэл	Тэгш, хүртээмжтэй байдлыг дэмжих	Хамтын ажиллагааг хөгжүүлэх	Нийгмийн хариуцлага, олон талт байдлыг хүндэтгэх

Үр дүнд суурилсан багш боловсролын хөтөлбөрийг харьцуулахад

Зураг 1. Харьцуулсан хөтөлбөрүүд дэх чадамжийн давтамж



Багш, бага боловсролын хөтөлбөрийн үр дүнг боловсруулахдаа:

- Уян хатан, бүтээлч, нийгэмд хариуцлагатай засаглалыг бий болгох
- Хүмүүнлэгийн үнэт зүйлийг бүх талаар дэмжих
- Амьдралын турш ур чадвар, чадамж эзэмшүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх, тогтвортой ирээдүйд бэлтгэх
- Цахим ба хүмүүний харилцааны ирээдүйг тэгш хүртээмжтэй, ёс зүйтэй болгох(Их сургуулиудыг өөрчлөх 7 чиглэл, 1999, 2030 он хүртэлх дээд боловсролын талаарх цоо шинэ төсөөлөл, 8 дахь тайлан) санааг чухалчилсан бөгөөд зарим нэг бодлогын баримт бичгээс дараах санаануудыг онцлон тусгасан. Үүнд:

1. а.Хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлэх, б. боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, в. Улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ. (Алсын хараа 2050, МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого)

2. Иргэний хөгжлийн хэрэгцээг хангахуйц чанартай, нээлттэй, тэгш хүртээмжтэй, уян хатан боловсролын үйлчилгээнд тулгуурлан мэдлэгт суурилсан нийгэм болон дижитал технологийн эринд ажиллаж амьдрах нийгмийн идэвхтэй оролцоо бүхий тасралтгүй хөгжих чадамжтай иргэнийг хөгжүүлэх(Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө, 2021-2030)

3. Багшлахуйгаас суралцахуйд, амьдралын турш суралцах, МТХ мэдлэг түгээх хэрэгсэл болгох, салбар хоорондын мэдлэг (Боловсролын өөрчлөлтийн шаардлага, (Jarvis P., 1989))

Өөрийн орны иргэний амьдралын хэвшил, соёлын онцлог байдал, монгол хүний сэтгэлгээний өвөрмөц байдал шинжийг судлан тогтоолгүй гадны боловсролын туршлагыг шууд хуулбарлан хэрэглэхгүй байх, (Бэгз.Н, 2017)

4. Үр дүнд суурилсан боловсролын үзэл баримтлалыг нэвтрүүлж, энэхүү үзэл баримтлал нь суралцагч бүрийн авьяас, чадварыг нээн хөгжүүлж, цогц чадамж олгох, түүнийг амьдралд хэрэгжүүлэх чадвартай, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, шинэ мэдлэг бүтээх чадамжтай “Дэлхийн иргэн”-ийг бэлтгэхэд чиглэж байх. Түүнчлэн хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тодорхойлохын тулд чадамжуудын хүрээнд тулгуурлан төгсөгч 420 багш, 103 ажил олгогчдоос судалгаа авсан. Судалгааны үр дүнг дээрх улс орнуудын суралцахуйн үр дүнтэй харьцуулсан.

Зураг 2. Багш нарын хандлагыг эрэмбэлсэн давтамж



Зураг 3. Багш нарын чадварыг эрэмбэлсэн давтамж



Харин багшийн хэрэгцээтэй байгаа мэдлэгийг эрэмбэлэхэд МХТ-ийн мэдлэг, судалгааны арга зүйн мэдлэг, монгол соёл, түүхийн мэдлэг, гадаад хэл зэргийг хамгийн өндөр давтамжтайгаар дурдсан. Түүнчлэн нөхцөл байдлын судалгаа, баримт бичгийн судалгаа болгож хийсэн харьцуулсан судалгаанд үндэслэн Багшийн сургуулийн хөтөлбөрийн зорилго, суралцахуйн үр дүнг дараах байдлаар тодорхойлсон. Олон улсын харьцуулалтаас харахад суралцахуйн үр дүн 6-12 үр дүнгээр тодорхойлогдсон байсныг эшлэл болгон ашигласан.


Хүснэгт 3. Хөтөлбөрийн зорилго суралцахуйн үр дүнгийн матриц

PEO	Хөтөлбөрийн зорилго	PLO	Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн
1. Үнэт зүйл	Хүүхдийн хэрэгцээ болон ялгаатай байдлыг нь ойлгодог, сурах хүсэл эрмэлзлийг нь төрүүлдэг, хүмүүнлэг, хүнлэг энэрэнгүй, үнэт зүйлээ эрхэмлэдэг багш байх	1.1	Бага ангийн суралцагчдад үндэсний хэл, соёл, уламжлалаа дээдлэх, танин мэдэх, бахархах эх оронч үзлийг төлөвшүүлэх, зөөлөн чадвар бүхий монгол сэтгэлгээтэй дэлхийн иргэнийг хөгжүүлэх чадамжтай байх
		1.2	Суралцагчдын ялгаатай байдлыг харгалзан тэгш хүртээмжтэй, хүндэтгэлтэй ханддаг байх
2. Мэдлэг	Судлагдахууны мэдлэгтэй, багшлахуй суралцахуйн онол, арга зүйг эзэмшсэн, хүүхдийн хөгжлийг оношилдог, оюунлаг багш байх	2.1	Бага ангийн суралцагчдын нас, бие, оюун ухаан, танин мэдэхүйн онцлог, хөгжих зүй тогтлын талаарх онолын мэдлэгээ хэрэглэх, эргэцүүлэх, хөгжүүлэх чадамжтай байх
		2.2	Судлагдахуун бүрийн онол, арга зүйн мэдлэг, ур чадвартай байх
		2.3	Сургалтыг нэгдмэл байдлаар төлөвлөх, зохион байгуулах, дүн шинжилгээ хийдэг байх
		2.4	Эерэг уур амьсгалтай, тэгш хамран сурах орчин бүрдүүлдэг байх
3. Чадвар	Тогтвортой хөгжил, сайн сайхан, монгол хүний үнэт зүйлийг эрхэмлэдэг, харилцаа, технологийн чадвартай, санаачлагч, хөгжүүлэгч, бүтээлч багш байх	3.1	Бага ангийн суралцагчдын суралцагч бүрийн тасралтгүй хөгжлийг оношилдог, үнэлгээгээр дэмждэг, хөгжүүлдэг байх
		3.2	МХТ-ийн чадамжтай, зохистой хэрэглээнд чиглүүлдэг, үлгэрлэдэг байх
		3.3	Инновац бүтээх, Энтрепренёр сэтгэлгээг төлөвшүүлэх, дэмжин хөгжүүлэх чадвартай байх
		3.4	Төсөөлөх, тодорхойгүй ирээдүйд бэлтгэх, дасан зохицох, хошигнох, сэтгэл хөдлөлөө удирдах чадвартай байх

4. Хандлага	Судлаач, мэдлэгээ бүтээлчээр хэрэглэдэг, асуудлыг хамтран шийдвэрлэдэг, боловсролын хөгжилд хувь нэмрээ оруулдаг, насан туршдаа тасралтгүй суралцагч багш байх.	4.1	Өөрийн хөгжлийг төлөвлөдөг, манлайлдаг, багаар ажиллах чадвартай, тасралтгүй хөгжигч мэргэжилтэн байх
		4.2	Суралцагчдын эцэг эх, асран хамгаалагч, олон нийттэй хүндэтгэлтэй харилцах, ойлголцох, ачаалал даах чадвартай байх

Суралцахуйн үр дүнг хичээлүүдийн суралцахуйн үр дүнтэй холбож тохирц нийцлийг үзэхэд дараах үр дүн гарсан.

Зураг 4. PLO, CLO матриц



Дээрх зургаас харахад багш боловсролын суралцахуйн үр дүнд чухал 5 чадварын нэгд дурдагдсан инновац бүтээх чадварыг хичээлүүдийн хөтөлбөрт бага тусгасан байдаг ба хамгийн их хамаарал үүсгэж тусгасан чадамжийн харгалзаа мэдлэг байсан бөгөөд хөтөлбөрүүдийн 70 хувь нь маш идэвхтэй харгалзаа үүсгэсэн байсан. Тиймээс бүтээгч багшийг хөгжүүлэхэд илүү анхаарах, мэдлэгээ хөгжүүлдэг инновацлаг багшийг бий болгох хөтөлбөрийн хөгжүүлэлт хийх хэрэгцээ үүсэж байна.

Дүгнэлт

Улс орнуудын багш боловсролын суралцахуйн үр дүнгийн хүрээ 6-12 чадамжийн хүрээгээр тодорхойлогдож тухайн улс орны хөтөлбөрийн үзэл баримтлал юуг эрхэмд үзэж суурь болгож томъёолсноос хамаарч эрэмбэлсэн байна. Бага боловсрол ихэвчлэн тухайн улсын иргэний суурь боловсрол хэмээн үздэгээс монгол хүнийг “төрүүлэх”, тийм багш хамгийн түрүүнд хүүхдэд хайртай, монгол хүний эрхэм чанарыг тээсэн байх явдал чухал гэж үзээд Багш, бага боловсролоор суралцагчдын хөтөлбөрийн суралцахуйн үр дүн үнэт зүйл дээр суурилан тасралтгүй хөгжигч, санаачлагч, хөгжүүлэгч, мэргэжлийн чадамжтай, оюунлаг бүтээгч багшийг бэлтгэх зорилго бүхий 12 суралцахуйн үр дүнг тодорхойлсон.

Хэдийвээр харьцуулсан судалгаа болон нөхцөл байдлын судалгааны хөтөлбөрийн үр дүнг цаасан дээр буулгасан ч эхний зорилт болгож хичээлүүдийн суралцахуйн үр

дүнд харгалзуулж үзэхэд бид хуучин хэвээрээ стандарт боловсруулж байгааг зураг 4-өөс харж болно. Тиймээс бид хичээл бүрийн стандарт боловсруулахдаа хичээл бүрийн суралцахуйн үр дүнг эргэн харах, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэйгээ уялдуулах нь өнөөгийн суралцагчийн хөгжлийн онцлог, нийгмийн хэрэгцээг тусгаж буй хэрэг болох учиртай.

Өнөөдөр үр дүнд суурилсан хөтөлбөр хэрэгжүүлэхдээ инновац, технологи ашиглах, хөгжүүлэх чадвар, судалгаанд суурилсан заах арга зүйг нэвтрүүлэх, суралцагч төвтэй арга зүйг хөгжүүлэх, бүтээлч шүүмжлэлт сэтгэлгээ, олон талт байдлыг хүндэтгэх хандлага төлөвшүүлэх багш хэрэгтэй байгааг үр дүн болгон төлөвлөх болжээ.

Ном зүй

1. Бадарч,Д,(2013). Системийн сэтгэлгээ, Уб
2. Spady,W.(1994). Outcome- Based education; Critical issues and answers
3. Biggs, J., Tang,C(2011). Teaching for quality learning at university
4. Bray,M., Adamson,B. (2014), Comparative education research
5. Jarvis P., (1989).Боловсролын өөрчлөлтийн шаардлага
6. Алсын хараа 2050, МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого
7. МУБИС-ийн Багш боловсролын үзэл баримтлал (2023)

COMPARATIVE ANALYSIS OF PROGRAM LEARNING OUTCOMES (PLOS) IN TEACHER EDUCATION: A CASE OF PRIMARY EDUCATION PROGRAMS

^aByambatseren G., ^bTamir Ts.

^aPh.D, associate professor, Teachers School, MNUE;

^bPh.D, Teachers School, MNUE

Corresponding author: byambatseren.edu.mn, ts.tamir @msue.edu.mn 

Abstract

A substantial body of literature has emphasized the importance of systems thinking in addressing educational issues, particularly in designing and implementing outcomes-based curricula. However, countries differ significantly in deciding which learning outcomes to modify, retain, or enhance when reformulating teacher education curricula. Without rigorous comparative research across systems, adopting international principles, theoretical approaches, and curriculum design frameworks becomes analogous to planting seeds in an unsuitable soil: innovative ideas cannot take root without contextual alignment.

The present study argues that the Program Learning Outcomes (PLOS) of teacher education require re-formulation, since existing outcomes tend to be excessively numerous, insufficiently measurable, and lack alignment with competency-based standards. By adopting global benchmarks where international teacher education programs typically cluster PLOS into six to twelve competency domains this study has proposed twelve outcome domains for the “Primary Education Teacher Education Program” in Mongolia. Although the Mongolian University of Science and Technology (MUST) previously introduced a model for OBE curriculum design, its methodological premises were originally developed within engineering education, and thus may not fully correspond to teacher education. Consequently, this study compares international curriculum development methodologies and competency models in teacher education to inform the redesign of national PLOS

Keywords

Teacher education; Program Learning Outcomes (PLOS); Quality of life; Competency; Systems thinking; Knowledge construction.
